



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/66/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Л.Соёлмөнх Утас: 7033-3019 Цахим хаяг: Soyolmunkhl@audit.gov.mn</p>
----------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс:976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

2023.02.13 № 27
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
П.УРАНЦЭЦЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1; Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Соёл урлагийн газар нь Бараа үйлчилгээний бусад зардлаас 12,280.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.
2. Аймгийн хэмжээний соёл урлагийн салбарын ажилтнуудыг хамруулсан танхимын сургалт зөвлөгөөнийг удаа дараа зохион байгуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулсан байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын 190 дүгээр тушаал, 2018 оны 134 дүгээр тушаалуудыг зөрчсөн бөгөөд аудитын *тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь 2021 оны 4 дүгээр улиралд Соёлын хэлтсээр байгуулагдсан бөгөөд 2022 онд Соёлын яаманд шилжин Соёл урлагын газар болон бүтэц, зохион байгуулалтанд орсон байна. Монгол улсын Соёлын сайдын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Аймаг, нийслэлийн Соёл, урлагийн газрын зохион

003020100

байгуулалтын бүтэц, дүрэм батлах тухай” А/04 тоот тушаалаар Соёл урлагийн газрын бүтэц зохион байгуулалтыг баталсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын төсөв захирагч нь Соёлын яамны сайдын 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн б/05 тоот тушаалаар даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр, мөн төрийн захиргааны нэр бүхий 1 албан хаагч түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Бусад асуудлын хэсэг

2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 3 үндсэн зорилтын хүрээнд 31 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,900,000.00	16,000,000.00
33	АВЛАГА	4,900,000.00	-
335	Бусад авлага	4,900,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	4,900,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	-	16,000,000.00
35400	Хангамжийн материал	-	16,000,000.00
35470	Бусад хангамжийн материал	-	16,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	24,079,699.91	214,827,824.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	24,079,699.91	214,827,824.12
392	Биет хөрөнгө	24,079,699.91	45,543,657.46
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	16,791,900.00	44,188,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,528,866.75)	(10,192,685.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,200,000.00	13,631,301.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(383,333.34)	(2,083,458.12)
393	Биет бус хөрөнгө	-	169,284,166.66
39301	Програм хангамж	-	1,340,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(55,833.34)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	168,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,979,699.91	230,827,824.12
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	28,979,699.91	230,827,824.12
51	Засгийн газрын хувь оролцоо	28,979,699.91	230,827,824.12
512	Хуримтлагдсан үр дүн	28,979,699.91	230,827,824.12
51210	Өмнөх үеийн үр дүн	28,979,699.91	28,979,699.91
51220	Тайлант үеийн үр дүн	28,979,699.91	201,848,124.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,979,699.91	230,827,824.12

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	72,669,400.00	482,011,701.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,639,900.00	174,027,401.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,639,900.00	174,027,401.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	3,639,900.00	174,027,401.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,029,900.00	307,981,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	210,831,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	210,831,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,990,000.00	68,950,000.00

Архангай аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,990,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	61,950,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,039,000.00	28,203,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,039,000.00	28,203,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	43,690,100.09	280,160,276.79
21	УРСГАЛ ЗАРДАЛ	43,690,100.09	280,160,276.79
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,355,122,44	260,880,465.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,661,704.50	121,557,249.37
210101	Үндсэн цалин	20,661,704.50	87,378,142.37
210102	Нэмэгдэл	-	14,192,396.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,198,110.00
210104	Урамшуулал	-	6,788,601.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,852,717.85	15,840,564.61
210201	Тэтгэврийн даатгал	1,756,249.67	10,772,469.87
210202	Тэтгэмжийн даатгал	206,617,04	1,267,348.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	165,293.64	1,073,867.10
210204	Ажилгүйдлийн даатгал	41,323.40	252,179.74
210205	Эрүүл мэндийн даатгал	413,234.10	2,474,699.39
2104	Хангамж, бараа материалын зардал	7,150,500.00	12,546,960.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	3,538,950.00
210402	Тээвэр, шатахуун	3,046,000.00	7,618,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,500.00	1,148,410.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		240,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,990,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,048,000.00	28,200,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	48,000.00	-
210604	Урсгал засвар	10,000,000.00	28,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	5,952,000.00
210702	Дотоод албан томилолт	-	5,952,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	7,923,840.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,340,340.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,398,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,912,200.09	68,045,351.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	43,295,915.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	14,329,660.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,912,200.09	10,419,776.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,334,977.65	19,283,111.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,786,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,786,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13,493,811.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	13,292,311.02
213304	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		201,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,334,977.65	3,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,334,977.65	3,300.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,979,699.91	201,848,124.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	28,979,699.91	201,848,124.21

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	69,029,900.00	307,984,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	69,029,900.00	307,984,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	210,831,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	210,831,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,990,000.00	68,950,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,990,000.00	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,000,000.00	61,950,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	61,039,000.00	28,203,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	61,039,000.00	28,203,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	46,677,900.00	275,843,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,677,900.00	275,843,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	45,342,922.35	256,560,688.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	20,661,704.50	121,557,249.37
210101	Үндсэн цалин	17,834,394.90	87,123,292.37
210102	Нэмэгдэл	2,827,309.60	14,447,246.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	13,198,110.00
210104	Урамшуулал	-	6,788,601.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,852,717.85	15,840,564.61
210201	Тэтгэврийн даатгал	1,756,249.67	10,772,469.87
210202	Тэтгэмжийн даатгал	206,617.04	1,267,348.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	165,293.64	1,073,867.10
210204	Ажилгүйдлийн даатгал	41,323.40	252,179.74
210205	Эрүүл мэндийн даатгал	413,234.10	2,474,699.39
2104	Хангамж, бараа материалын зардал	10,060,500.00	9,646,975.00
210401	Бичиг хэрэг	3,200,000.00	3,538,965.00
210402	Тээвэр, шатахуун	5,946,000.00	4,718,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	514,500.00	1,148,410.00
210404	Ном, хэвлэл	400,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	240,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,048,000.00	28,200,000.00
2106	Багаж, техник, хэрэгсэл	48,000.00	-
210604	Урсгал засвар	10,000,000.00	28,200,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	5,952,000.00
210702	Дотоод албан томилолт	-	5,952,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	8,738,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,340,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	5,398,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,990,000.00	66,625,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,990,000.00	62,395,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	11,229,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,334,977.65	19,283,111.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	5,786,000.00

Архангай аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	5,786,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	13,493,811.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		13,292,311.02
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		201,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,334,977.65	3,300.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,334,977.65	3,300.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	22,352,000.00	25,140,500.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	22,352,000.00	25,342,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,352,000.00	25,140,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	22,352,000.00	25,140,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	22,352,000.00	25,140,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	22,352,000.00	-25,140,500.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл				
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
C07	Тайлант үеийн үр дүн			28,979,699.91	28,979,699.91
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			28,979,699.91	28,979,699.91
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			28,979,699.91	28,979,699.91
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
D08	Тайлант үеийн үр дүн			201,848,124.21	201,848,124.21
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			230,827,824.12	230,827,824.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Харьцуулалт
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	210,831,000	197,538,689	13,292,311	93.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	210,831,000	197,538,689	13,292,311	93.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	205,045,000	191,752,689	13,292,311	93.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	130,336,800	121,557,249	8,779,551	93.26
210101	Үндсэн цалин	95,036,800	87,123,292	7,913,508	91.67
210102	Нэмэгдэл	22,100,000	14,447,246	7,652,754	65.37
210103	Унаа хоолны хөнгөлөлт	13,200,000	13,198,110	1,890	99.99
210104	Урамшуулал	-	6,788,601	(6,788,601)	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,154,600	15,840,565	4,314,035	78.60
210201	Тэтгэврийн даатгал	13,405,100	10,772,470	2,632,630	80.36
210202	Тэтгэмжийн даатгал	1,687,400	1,267,349	420,051	75.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,349,900	1,073,867	276,033	79.55
210204	Ажилгүйдлийн даатгал	337,500	252,180	85,320	74.72
210205	Эрүүл мэндийн даатгал	3,374,700	2,474,699	900,001	73.33
2104	Хангамж, бараа материалын зардал	9,797,200	9,646,975	150,225	98.47
210401	Бичиг хэрэг	4,050,500	3,538,965	511,535	87.37
210402	Тээвэр, шатахуун	4,718,800	4,718,800	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	642,200	1,148,410	(506,210)	178.82
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,900	-	144,900	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,800	240,800	-	100.00
2107	Томилолт, зочны зардал	6,000,000	5,952,000	48,000	-
210702	Дотоод албан томилолт	6,000,000	5,952,000	48,000	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,013,400	4,013,400	-	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,013,400	4,013,400	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,743,000	34,742,500	500	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,513,400	23,512,900	500	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,229,600	11,229,600	-	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,786,000	5,786,000	-	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,786,000	5,786,000	-	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,786,000	5,786,000	-	100.00

Архангай аймгийн Соёл урлагийн газрын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	210,831,300	210,381,300	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	210,831,000	210,831,000	-	100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	210,831,000	210,831,000	-	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	11	11	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,950,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	51,949,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,748,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,398,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,398,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,350,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	201,500.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	201,500.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	201,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,000,500.00
	Дотоод эх үүсвэрээр	17,000,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	17,000,500.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	68,950,000.00
1311	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	68,950,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	61,950,000.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа¹ илрээгүй, харин залруулагдаагүй нийт 12,280.0 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 12,280.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

5.2.1 Нийт зардлыг анхан шатны баримтаар тулган шалгахад аймгийн хэмжээний соёл урлагийн салбарын ажилтнуудыг хамруулсан танхимын сургалт зөвлөгөөнийг удаа дараа зохион байгуулж төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлт, үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.5 "салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3 "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.2.2 Бараа үйлчилгээний бусад зардлаас 12,280.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний 190 дүгээр тушаал, 2018 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн 134 дүгээр тушаалын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын нэгж байхгүй, тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтанд нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Иймд Төсвийн тухай хуулийн 16.5.2-д заасны дагуу байгууллагын дотоод хяналтыг нэгжийг байгуулан, дотоод хяналт ажлын жилийн төлөвлөгөөг боловсруулж, байгууллагын төсөв санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгөд хяналт тавьж ажиллах

5.3.2 Шилэн данснтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Соёл урлагийн газар нь тайлант онд шилэн дансны цахим хуудсанд нийт 151 мэдээллийг байршуулбал зохицоос 16 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.10-д заасан “төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийг мэдээллэх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Соёл урлагийн газар	3	12,280	-	-	2	12,280	1	0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Соёл урлагийн газар	1	-	-	-	-	-	-	-	-	1	0	